

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ:

“Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-ийн 4.3, 4.7, 4.8 дахь заалт, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 11, 12, 13, 14 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 35 дугаар зүйлийн 35.2, 35.3 дахь заалт Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 49 дүгээр тогтоол

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх материалын жагсаалт	Тайлбар
1	Тусгай зөвшөөрөл хүссэн албан тоот	Эрхлэх үйлчилгээний төрөл, оноосон нэр, байршил, хаяг, харилцах утас, факсыг тодорхой дурдах
2	Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	
3	Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчын үйлдвэрлэл, үйлчилгээнд хийсэн эрсдэлийн үнэлгээ	
4	Аймгийн Стандартчилал, хэмжилзүйн төвөөс худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийсэн гэрчилгээний хуулбар	
5	Аймгийн Онцгой байдлын газраас тухайн үйлчилгээний газрын галын аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлтийн хуулбар	
6	Тухайн үйлчилгээний барилгын батлагдсан зураг төсөл, барилгыг хүлээн авсан улсын комиссын актын хуулбар	